



**МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 12 сарын 20 өдөр

Дугаар А/650

Хэрлэн сум

Д.Галхүүд дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэрлэн сумын 4 дүгээр багийн иргэн Д.Галхүүгийн өргөдлийн дагуу өрх толгойлсон 6 хүүхэдтэй эх Б.Бишүүгармаагийн амьжиргааг дэмжиж, хүүхэд амьдрах ая тухай орчныг бүрдүүлэх үйл ажиллагааны зардалд зориулж, 500,000 (таван зуун мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дэмжлэгт шаардагдах хөрөнгийг Засаг даргын нөөц сангийн байгууллага иргэдээс тавьсан хүсэлтийг шийдвэрлэх зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ